



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

ЭДИЙН ЗАСАГ,  
ХӨГЖЛИЙН ЯАМ

# МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2023 оны III улирал

## **Агуулга**

Хураангуй дүгнэлт.....	1
1. Бодит сектор.....	3
Нийт нийлүүлэлт.....	3
Нийт эрэлт.....	5
Эдийн засгийн мөчлөг.....	7
2. Төсвийн сектор.....	10
3. Мөнгө ба санхүүгийн сектор.....	12
Инфляц ба мөнгөний бодлого.....	12
Санхүүгийн сектор.....	14
4. Гадаад сектор.....	17
Гадаад худалдаа.....	17
Төлбөрийн тэнцэл.....	18

## **Зургийн жагсаалт**

Зураг 1. Бодит ДНБ-ий өсөлт.....	3
Зураг 2. Өсөлт, түүний бүтэц.....	5
Зураг 3. Өрхийн санхүү.....	6
Зураг 4. Үйлдвэрлэлийн зөрүү.....	7
Зураг 5. Хөдөлмөр эрхлэлт.....	8
Зураг 6. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам.....	9
Зураг 7. Дундаж цалин.....	9
Зураг 8. Төсвийн орлого, зарлагын өөрчлөлт.....	10
Зураг 9. Инфляцын бүтэц.....	12
Зураг 10. Жилийн инфляц ба суурь инфляц (хувь).....	13
Зураг 11. Мөнгөний үзүүлэлт.....	14
Зураг 12. Арилжааны банкны хураангуй тайлан.....	14
Зураг 13. Зээл.....	15
Зураг 14. Экспорт, импорт.....	18
Зураг 15. Төлбөрийн тэнцэл, урсгал дансны тэнцэл.....	19
Зураг 16. Гадаад валютын албан нөөц.....	20
Зураг 17. Гадаад хөрөнгө оруулалтын позиц.....	20
Зураг 18. Гадаад өр.....	21
Зураг 19. Дотоодын зах зээл дэх ноолуурын үнэ.....	24
Зураг 20. Арьс ширний экспорт.....	24
Зураг 21. Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс.....	25
Зураг 22. Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ.....	25
Зураг 23. Дизелийн түлшний импорт.....	26
Зураг 24. Бензиний импорт.....	26

## **Хүснэгтийн жагсаалт**

Хүснэгт 1. Төсвийн үзүүлэлтүүд.....	11
Хүснэгт 2. Угаасан болон самнасан ноолуурын экспорт.....	22

## **Шигтгээний жагсаалт**

Шигтгээ 1. Ноос, ноолуурын хялгас ялгах үйлдвэрүүдэд хийсэн хяналт шалгалт.....	22
Шигтгээ 2. Арьс шир, ноолуурын гадаад худалдаа.....	24

Шигтгээ 3. Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс .....	25
Шигтгээ 4. Нефтийн бүтээгдэхүүний импорт.....	26

## Хураангуй дүгнэлт

Дотоодын нийт бүтээгдэхүүн 2023 оны эхний 3 улиралд нэрлэсэн дүнгээр 29.5 хувиар, үнийн өөрчлөлтийн нөлөөг арилгасан бодит дүнгээр 6.9 хувиар тус тус өслөө.

**Нийлүүлэлт талаас:** Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйгаас бусад салбарууд эерэг нөлөө үзүүллээ. Гадаад валютын албан нөөц, экспортыг нэмэгдүүлэх чиглэлд хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнд уул уурхай болон тээврийн салбар эдийн засгийн өсөлтөд голлон нөлөөллөө. Өвөлжилт, хаваржилтын хүндрэлээс хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл буурч, эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлсөн байна.

**Эрэлт талаас:** Эрэлт талаас тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн 7.1 хувиар өслөө. Нүүрсний экспорт эрчимжсэнээр барааны экспорт өмнөх оны мөн үеэс даруй 66.5 хувиар нэмэгдэж, гадаад эрэлтийн сайн төлөв хадгалагдсан бол Засгийн газраас цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлснээр төрийн болон өрхийн хэрэглээ нэмэгдэж, эдийн засгийн дотоод эрэлт мөн идэвхэжлээ. Инфляц саарч, ханш тогтворжин, цалин, тэтгэвэр, тэтгэмж өссөнөөр өрхийн бодит орлого 11.9 хувиар сайжирчээ.

**Инфляц:** Жилийн инфляц 11 дүгээр сарын байдлаар 8.6 хувь болж өмнөх оны хагас жилээс хойш алгуур буурсаар байна. Үүний 3.1 нэгж хувийг импортын гаралтай инфляц, 5.5 нэгж хувийг дотоодын бараа, үйлчилгээний инфляц бүрдүүлж байна. Инфляц буурахад импортын барааны үнийн өсөлт саарсан ба дотоодын зарим гол бүтээгдэхүүний үнийн өсөлт буурсан нь голлон нөлөөллөө.

**Мөнгөний сектор:** Мөнгөний нийлүүлэлт энэ оны 10 дугаар сарын байдлаар 33.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.4 их наяд төгрөгөөр нэмэгдэхэд төгрөгийн хадгаламж болон төгрөгийн харилцах өссөн нь голлон нөлөөллөө. Банкны салбарын нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.5 их наяд төгрөгөөр өссөн ба зээлийн өсөлтийн дийлэнх хэсгийг иргэдийн зээлийн өсөлт бүрдүүлэв.

**Гадаад тэнцэл:** Нүүрсний экспортын хэмжээ нэмэгдсэнээр энэ оны эхний 3 улирлын байдлаар урсгал дансны ашиг улирлын түүхэн дээд түвшинд хүрч, төлбөрийн тэнцэл өмнөх оны мөн үеэс 2.3 тэрбум ам.доллараар сайжирч, гадаад валютын албан нөөц 4 тэрбум ам.долларыг давлаа.

### Богино хугацааны эдийн засгийн төлөв

**Эдийн засгийн өсөлт:** Уул уурхайн бүтээгдэхүүний гадаад эрэлт өндөр, экспорт тогтвортой нэмэгдсэнээр уул уурхайн болон тээврийн салбар 2023 оны эдийн засгийн өсөлтөд голлон нөлөөлнө. 2024 онд уул уурхайн бүтээгдэхүүнүүд, Оюутолгойн гүний уурхайн олборлолт эрчимжиж, зэсийн баяжмал дахь агууламж нэмэгдсэнээр уул уурхайн салбар эдийн засгийн өсөлтийг дэмжинэ. Мөн хөдөө аж ахуй, боловсруулах, барилга болон худалдаа, үйлчилгээний салбаруудын үйл ажиллагаа эдийн засагт эергээр нөлөөлнө.

**Инфляц:** Инфляц 2023 оны эцэст нэг оронтой тоонд хадгалагдахаар байна. Мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр зээлийн хүү өсөж, зээл олголт буурч эхэлсэн, мөн өмнөх оны суурь үнэ өндөр байсан зэрэг шалтгаануудын улмаас инфляц буурах хүлээлттэй байна. Засгийн газар, төв банкнаас макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд хэрэгжүүлж буй төсөв, мөнгөний хатуу бодлого, мөн экспорт болон валютын орох урсгалыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн үр дүнд инфляц 2024 онд Монголбанкны дунд хугацааны зорилтот түвшин болох  $6 \pm 2$  хувь орчимд хадгалагдахаар байна.

Төв банк бодлогын хүүг 13 хувьд хадгалснаар инфляцыг зорилтот түвшин рүү бууруулж, тогтворжуулах, макро эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдэж байна.

**Гадаад тэнцэл:** Засгийн газраас хэрэгжүүлж буй экспорт, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, Засгийн газрын гадаад өрийн зохицуулалтын арга хэмжээ гадаад валютын нөөцийн дарамтыг бууруулж, төлбөрийн тэнцэл 2023 болон 2024 онд ашигтай гарахаар төсөөлж байна. Гадаад эдийн засагт геополитикийн хямралт байдал үргэлжилсэн хэвээр, санхүүгийн нөхцөл чанга, гадаад шокийн эрсдэл өндөр байгаа энэ үед манай улс гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх чиглэлд үргэлжлүүлэн анхааран ажиллаж байна.

# 1. Бодит сектор

## Нийт нийлүүлэлт


### Товч дүгнэлт

Гадаад валютын албан нөөц, экспортыг нэмэгдүүлэх чиглэлд хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнд уул уурхай болон тээврийн салбар эдийн засгийн өсөлтөд голлон нөлөөлсөн хэвээр байна. Нүүрс болон газрын тосны олборлолт, зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдсэн нь уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, экспортод гарах уул уурхайн бүтээгдэхүүний өсөлт тээврийн салбарын өсөлтийг тэтгэж байна. Уул уурхай болон тээврээс бусад салбарын үйл ажиллагаа 3 дугаар улирлаас идэвхжихэд боловсруулах, худалдаа, зочид буудал, нийтийн хоол, мэдээлэл холбоо болон төрийн удирдлагын салбарын өсөлт нөлөөллөө. Харин оны эхнээс өвөлжилт, хаваржилт хүндэрсний улмаас малын хорогдол 2009 оноос хойших дээд хэмжээнд хүрч, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл буурсан байна.

**Эдийн засгийн өсөлт хадгалагдаж байна.** Нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2023 оны эхний 3 улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 46.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 29.5 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 21.7 их наяд төгрөг болж, өмнөх оноос 6.9 хувиар тус тус өслөө. Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйгаас бусад салбарууд эерэг нөлөө үзүүллээ. Тухайлбал, уул уурхайн салбар 33 хувиар, тээврийн салбар 58 хувиар, бөөний болон жижиглэн худалдааны салбар 6.1 хувиар, үйлчилгээний салбар 8.7 хувиар тус тус тэлсэн нь эдийн засгийн нийт өсөлтийг голлон дэмжсэн байна.

Зураг 1. Бодит ДНБ-ий өсөлт

1. Эдийн засгийн өсөлт дэх салбаруудын оролцоо (нэгж хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо  
Тэмдэглэл: Бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт дэх салбаруудын оруулах хувь нэмрийг харуулав.

2. Салбаруудын өсөлт (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо  
Тэмдэглэл: Бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлтийг уул уурхай болон уул уурхайн бус салбараар харуулав.

Гадаад валютын албан нөөц, экспортыг нэмэгдүүлэх чиглэлд хэрэгжүүлж буй цогц арга хэмжээний үр дүнд уул уурхай, тээврийн салбарууд эдийн засгийн нийт өсөлтийн дийлэнхийг бүрдүүлж байна. Нүүрс олборлолт энэ оны эхний 3 улиралд 55.6 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.8 дахин, цар тахлын өмнөх үе буюу 2019 оны мөн үеэс 1.5 дахин нэмэгдээд байна. Оюутолгойн далд уурхайн үйлдвэрлэл энэ оны 3 дугаар сард эхэлснээр зэсийн баяжмал үйлдвэрлэл 1,051 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 19.9 хувиар өсжээ. Түүнчлэн, өмнөх оны эхний хагаст хилийн боомтын үйл ажиллагааны хязгаарлалтаас үүдэн зогсоод байсан газрын тос олборлолт сэргэж, 3.7 сая баррельд хүрч, өмнөх оноос 2.8 дахин нэмэгдсэн байна. Харин алт олборлолт 10.9 тоннд, төмрийн хүдрийн олборлолт 5.6

сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс тус тус 23 болон 29 хувиар буурсан бөгөөд 2019 оны түвшинд хүрээгүй хэвээр байна.

**Уул уурхайн бүтээгдэхүүн, нүүрсний тээвэр нэмэгдсэнээр тээврийн салбарын сэргэлт үргэлжилж байна.** 2023 оны эхний 3 улиралд бүх төрлийн тээврээр /авто зам, төмөр зам, агаар/ тээвэрлэсэн ачаа өмнөх оны мөн үеэс 59 хувиар өсөж, 79 сая тоннд хүрсэн бөгөөд үүний 61 сая тонн буюу 78 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлж байна. Тухайлбал, авто замаар тээсэн ачаа 2.4 дахин, төмөр замаар тээсэн ачаа 23 хувиар өсөхөд уул уурхайн бүтээгдэхүүний тээвэр голлон нөлөөлжээ.

**Өрхийн бодит орлого нэмэгдсэн болон уул уурхайн салбарын сэргэлтийн дам нөлөөгөөр бөөний болон жижиглэнгийн худалдаа болон зочид буудал, нийтийн хоол, мэдээлэл холбооны салбаруудын идэвхжил нэмэгдлээ.** Уул уурхай, тээврээс бусад салбарын үйл ажиллагаа 3 дугаар улирлаас идэвхэжлээ. Өмнөх улиралд 0.8 хувиар өссөн уул уурхай болон тээврээс бусад салбарын бодит үйлдвэрлэлийн өсөлт нэмэгдэж, 3 дугаар улиралд 3.4 хувиар өслөө. Үүнд боловсруулах, худалдаа, зочид буудал, нийтийн хоол, мэдээлэл холбоо болон төрийн удирдлагын салбарын өсөлт нөлөөллөө. Худалдааны салбарын борлуулалтын орлого 19 хувиар өсөж, 31 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд хүнсний бүтээгдэхүүний худалдаа 24 хувиар, хүнсний бус бүтээгдэхүүний худалдаа 18 хувиар тус тус өссөн байна. Мөн зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээний салбаруудын орлого эхний 3 улиралд 42 болон 28 хувиар нэмэгджээ. Мэдээлэл холбооны салбарын борлуулалт үйлчилгээний орлого 2023 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 21 хувиар өслөө. Уг өсөлтөд үүрэн холбооны салбарын зах зээлд нэвтэрсэн "Ондо" ХХК-ийн үйл ажиллагаа голлон нөлөөлөв.

**Мал, мах боловсруулах үйлдвэрлэлийн өсөлтийн нөлөөгөөр боловсруулах салбарын өсөлт хадгалагдаж байна.** Боловсруулах салбарын үйлдвэрлэл 2023 оны эхний 3 улиралд 14 хувиар өссөний 9 нэгж хувийг мах боловсруулах, консервлох үйлдвэрлэл бүрдүүлж байна. Цаг агаарын хүндрэлээс зах зээлд нийлүүлэх мал, махны тоо, хэмжээ нэмэгдэж мах боловсруулах үйлдвэрлэлийн өсөлтөд голлон нөлөөлөв.

**Барилгын материалын нийлүүлэлтийн тасалдлаас үүдэлтэй үнийн өсөлтийн нөлөөгөөр барилгын салбарын өсөлт удааширлаа.** 2023 оны 3 дугаар улирлын байдлаар нийслэлийн орон сууцны үнэ байршлаас шалтгаалан өмнөх оны мөн үеэс 11-32 хувиар өсөж орон сууцны барилгын өсөлт удааширлаа. Мөн үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах шилжүүлэх үйл ажиллагааны орлого 55 тэрбум төгрөг буюу 4 хувиар, түрээслэх, түрээслүүлэх үйл ажиллагааны орлого 18 тэрбум төгрөг буюу 13 хувиар тус тус буурлаа. Харин орон сууцны бус барилгын угсралт, засвар өмнөх оны мөн үеэс 20 хувиар өссөн нь барилгын салбарын өсөлтөд голлон нөлөөлөв.

**Өвөлжилт, хаваржилтын хүндрэлээс хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл буурч эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөв.** Оны эхнээс өвөлжилт, хаваржилт хүндэрснээс шалтгаалан 2023 оны эхний 3 улиралд төл бойжилт 27 хувиар буурч, малын хорогдол өмнөх оноос 10.9 дахин (2009 оноос хойших хамгийн өндөр хоргодол) өсөж, мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг буурууллаа. Түүнчлэн 2023 онд тариалсан нийт талбай өмнөх оны мөн үеэс 4 хувиар нэмэгдсэн ч үр тариа тариалсан талбай өмнөх оноос 5 хувь буурсан бөгөөд 3 дугаар улирлын байдлаар хураасан үр тариа өмнөх оноос 61 хувиар, төмс 35 хувиар тус тус бага байна.

## Нийт эрэлт

### Товч дүгнэлт

Эрэлт талаас тооцсон бодит дотоодын нийт бүтээгдэхүүн 7.1 хувиар өслөө. Өсөлтөд гадаад эрэлт, хэрэглээ, үндсэн хөрөнгийн хуримтлал эерэг нөлөө үзүүлэв. Энэ оны эхний 3 улиралд нүүрсний экспорт 48.9 сая тоннд хүрч, барааны экспорт өмнөх оны мөн үеэс даруй 66.5 хувиар нэмэгдсэн нь гадаад тэнцвэрийг сайжруулж байна. Засгийн газар цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлж, хүүхдийн мөнгийг нөхөж олгох шийдвэр гаргаснаар төрийн болон өрхийн хэрэглээ өсөж, дотоод эрэлт мөн идэвхжилээ. Инфляц саарч, ханш тогтворжин, цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдсэнээр хэрэглээнд ирэх дарамт буурч, өрхийн бодит орлого 11.9 хувиар сайжирсан байна.

**Гадаад эрэлт эдийн засагт өсөлт бий болгосоор байна.** Эрэлт талаас эдийн засаг бодит дүнгээр 7.1 хувиар өслөө. Өсөлтөд цэвэр экспорт 11.8 нэгж хувь, өрхийн хэрэглээ 3.5 нэгж хувь, төрийн хэрэглээ 3.4 нэгж хувь, үндсэн хөрөнгийн хуримтлал 2.7 нэгж хувийн тус тус эерэг нөлөө үзүүлсэн бол эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт өсөлтийг 14.3 нэгж хувиар бууруулсан байна. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хэрэгжилтийн үр дүнд нүүрсний экспорт энэ оны эхний 3 улиралд 48.9 сая тонн, эхний 11 сарын байдлаар 62.3 сая тоннд хүрч төсөөллөөс давсан. Ингэснээр оны эхний 3 улирлын байдлаар бараа, үйлчилгээний экспорт өнгөрсөн оны мөн үеэс 66.5 хувиар өсөж, төсөвт төвлөрүүлсэн уул уурхайн салбарын орлого 3.5 дахин нэмэгдэн, гадаад худалдааны алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 35.2 хувиар бууран гадаад эрэлтийн төлөв сайн байв.


**Төсвийн зарцуулалт дотоод эрэлтийг тэтгэсэн байна.** Засгийн газраас өрхийн амьжиргааг дэмжих хүрээнд цалин, тэтгэвэр, тэтгэмж, халамжийг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс нэмэгдүүлэх шийдвэр гаргасан. Үр дүнд нь төрийн хэрэглээ 4.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 20.8 хувиар тэлсэн нь дотоод эрэлтийг идэвхжүүлэхэд нөлөөлсөн байна.

### Зураг 2. Өсөлт, түүний бүтэц


1. ДНБ-ий өсөлтийн бүтэц (нэгж хувь)



2. Бараа, үйлчилгээний экспорт, импортын өсөлт (хувь)



3. Хөрөнгийн хуримтлалын өсөлтийн бүтэц (нэгж хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо  
Тэмдэглэл: Оны эхнээс өссөн бодит дүнгийн өсөлт болно.

**Инфляц саарч, өрхийн нэрлэсэн цалин нэмэгдсэнээр өрхийн бодит орлого өслөө.** Өнгөрсөн оны эхний хагаст төгрөгийн ханш огцом суларснаар иргэдийн бодит орлого 2022 оны эцэст 0.7 хувиар, 2023 оны эхний улиралд 3.9 хувиар тус тус буураад байв. Энэ оны эхнээс төгрөгийн ханш тогтворжиж, инфляц аажмаар саарч, нэрлэсэн цалин өссөнөөр өрхийн хэрэглээнд ирэх дарамт буурч, өрхийн бодит орлого өнгөрсөн оны мөн үеэс 11.9 хувиар сайжирснаар өрхийн хэрэглээ 2023 оны эхний 3




улиралд өнгөрсөн оны мөн үеэс 5.1 хувиар тэлж, нийт эрэлтэд эергээр нөлөөллөө. Өрхийн бодит орлогын өсөлтөд нэрлэсэн цалингийн орлого өнгөрсөн оны мөн үеэс 366 мянган төгрөг буюу 41.9 хувиар, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 77 мянган төгрөг буюу 18.3 хувиар өссөн нь голлон нөлөөллөө. Харин мал аж ахуйн салбарын гарц муу байсны улмаас өрхүүдийн мал аж ахуйн орлого өнгөрсөн оны мөн үеэс 25.0 хувиар буурсан байна.

**Хэрэглээний зээл олголт нэмэгдэж, өрхийн хэрэглээг идэвхжүүлж байна.** Өрхийн дундаж орлого 11.9 хувиар, өрхийн дундаж зарлага 14.3 хувиар тус тус өслөө. Үүний зэрэгцээ иргэдийн зээлийн үлдэгдэл 16.2 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 37.7 хувиар өссөн байна. Мөн иргэдэд олгосон хадгаламж барьцаалсан болон цалин, тэтгэврийн зээл 9.7 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 2.9 их наяд буюу 42.1 хувиар өссөн байна. Үүнд зээлийн үйлчилгээ сайжирч, онлайн-аар зээл авахад хялбар болсон болон арилжааны банкнууд энэ төрлийн богино хугацаатай зээлийг түлхүү олгох хандлага зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна.

**Зураг 3. Өрхийн санхүү**

1. Өрхийн сарын дундаж бодит орлого, зарлагын өсөлт (хувь)



2. Иргэдэд шинээр олгосон зээл (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа; Монголбанк  
Тэмдэглэл: Тухайн улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулсан өрхийн бодит орлого, зарлага болон тухайн улиралд шинээр олгосон зээлийг харуулав.

**Үндсэн хөрөнгийн хуримтлал нэмэгдэж, эргэлтийн хөрөнгө буурав.** Үндсэн хөрөнгийн хуримтлал энэ оны эхний 3 улиралд 8.6 хувиар өсөхөд орон сууцны бус барилга байгууламж 10.0 нэгж хувийн, машин тоног төхөөрөмж 1.8 нэгж хувийн, орон сууцны барилга 1.7 нэгж хувийн тус тус эерэг нөлөө үзүүлсэн байна. Харин бие гүйцсэн малын тоо 48.7 хувиар буурч, 2.1 нэгж хувийн, оюуны өмч 58.7 хувиар буурч, 2.8 нэгж хувийн тус тус бууруулах нөлөөг үзүүлсэн байна.

Арилжааны банкнуудын шинээр олгосон зээлийн хэмжээ оны эхний 3 улиралд 30.0 их наядад хүрсэн. Үүнээс 13.4 их наяд төгрөгийг аж ахуй нэгж байгууллагуудад олгосон нь өнгөрсөн оны мөн үеэс 17.5 хувиар өссөн байна. Төсвийн хөрөнгө оруулалт оны эхний 3 улиралд 2.8 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 30.2 хувиар тус тус өссөн бол гадаадын шууд хөрөнгө оруулалт 1,006 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 7.2 хувиар буурсан байна.

Нөгөө талаас оны эхний 3 улирлын байдлаар төл бойжилт 18.1 сая толгойд хүрч, өмнөх оноос 6.6 сая толгой буюу 26.6 хувиар буурсан болон өмнөх онд эргэлтийн хөрөнгийн хуримтлалд өндөр дүнгээр бүртгэгдэж байсан олборлосон нүүрсний овоолго буурсан нь эргэлтийн хөрөнгийн хуримтлал өмнөх оны мөн үеэс 82.4 хувиар буурахад нөлөөллөө.

## Эдийн засгийн мөчлөг


### Товч дүгнэлт

Эдийн засгийн нийт үйлдвэрлэл 2023 оны 3 дугаар улирлын байдлаар боломжит хүчин чадлаасаа 0.3 хувиар доогуур гарч өмнөх улиралтай харьцуулахад үйлдвэрлэлийн сөрөг зөрүү буурлаа. Үүнд уул уурхай, тээврийн салбарын сэргэлтийн дам нөлөөгөөр эдийн засгийн үйл ажиллагааны бусад салбарууд идэвхжин өрхийн бодит орлого болон эцсийн хэрэглээ өссөн нь голлон нөлөөллөө. Тайлант улиралд өмнөх оны мөн үеэс ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин буурлаа. Мөн сүүлийн 4 улирал дараалан ажиллах хүч буурч, ажиллах хүчнээс гадуурх хүн ам тэллээ. Хөдөлмөр эрхлэлтэд худалдаа, уул уурхай, эрчим хүч, тээвэр, барилгын салбар эергээр, үйлчилгээ, боловсруулах, мэдээлэл холбоо, хөдөө аж ахуйн салбарууд сэргөөр нөлөөллөө.

Эдийн засаг 6 улирал дараалан өсөж, мөнгөний нөхцөл аажмаар хатуурч, инфляцын түвшин тогтворжин уналтын зөрүү алгуур хаагдаж байна. 2023 оны 3 дугаар улирлын байдлаар бодит ханш чангарснаар импортын барааны үнийн өсөлт саарч байна. Тухайлбал, инфляц өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.7 нэгж хувиар буурсны 4.2 нэгж хувь нь импортын инфляцын бууралт байв. Харин дотоодын инфляц 0.5 нэгж хувиар өслөө. Цар тахал болон ОХУ-Украины дайнаар өдөөгдсөн инфляцын нөлөөтэй бодит хүүний түвшний сөрөг зөрүү арван улирлын дараа эерэг боллоо. Түүнчлэн, бодлогын хүүний түвшинг 2022 оны 2 дугаар улирлаас эхлэн 6 хувиас алгуур нэмэгдүүлж, 2022 оны 12 дугаар сард 13 хувьд хүргэсэн нь 3 улирлын дараагаас мөнгөний нөхцөлийг хатууруулах нөлөө үзүүлж эхэллээ.

### Зураг 4. Үйлдвэрлэлийн зөрүү


1. Үйлдвэрлэлийн зөрүү (потенциал ДНБ-д эзлэх хувь)




Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Тэмдэглэл: Үйлдвэрлэлийн функцийн аргаар тооцов.

2. Мөнгөний нөхцөлийн индекс (MCI)



3. Бодит хүүний түвшний зөрүү /GAP/ (нэгж хувь)




Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Тэмдэглэл: Калманы шүүлтүүрийн аргаар тооцов.

Ажилчдын тоо 2023 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 мянган хүнээр нэмэгдсэн ч өсөлтийн хурд бага байна. Салбараар авч үзвэл, ажилчдын тооны өсөлтөд худалдаа, уул уурхай, эрчим хүч, тээвэр, барилгын салбарын ажилчид эергээр нөлөөлсөн бол үйлчилгээ, боловсруулах, мэдээлэл холбоо, хөдөө аж ахуйн салбарын ажилчдын тооны өөрчлөлт сөргөөр нөлөөллөө. Хүйс болон насны бүлгээр харвал, эрэгтэйчүүд болон 50-аас дээш насны ажилчид нийт өсөлтөд голлох нөлөө үзүүлээ. Ажилгүй иргэдийн тоо 2023 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 2 мянган хүнээр, цар тахлын өмнөх түвшнээс 2 дахин тус тус буурч, 66 мянгад хүрлээ.

### Зураг 5. Хөдөлмөр эрхлэлт


1. Ажилчдын тоо, түүний өөрчлөлт (мянган хүн, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тэмдэглэл: Ажилчдын тооны өөрчлөлтийг өмнөх оны мөн үеэс өөрчлөгдсөн хувиар тооцоо.


2. Ажилчдын тооны өөрчлөлт (мянган хүн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тэмдэглэл: Өмнөх оны мөн үетэй харьцуулсан ажилчдын тооны өөрчлөлтийг салбар бүрээр харуулав.

3. Ажилчдын тооны өөрчлөлт (хүйс болон насны бүлгээр, мянган хүн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тэмдэглэл: Тайлант улралд ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс тооцсон өөрчлөлтийг хүйсээр, насны бүлгээр ангилан харуулав.

4. Ажилгүйдлийн түвшин, ажиллах хүчний оролцооны түвшин (хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тэмдэглэл: Ажиллах хүчний оролцооны түвшин (хөдөлмөрийн насны хүн амд эзлэх ажиллах хүчийг хувиар илэрхийлсэн үзүүлэлт), ажилгүйдлийн түвшин (ажилгүй хүний тоог ажиллах хүчинд харьцуулж тооцсон)-ийг тухайн улрлаар харьцуулан харуулав.

Ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо цар тахлын өмнөх түвшнээс өндөр хэвээр байна. Ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 877 мянган хүнд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 10 мянган хүнээр, цар тахлын өмнөх үеэс 27 мянган хүнээр тус тус өндөр үзүүлэлт байна. Хүйсээр ангилан харвал, ажиллах хүчнээс гадуурх хүн амын дийлэнх буюу 64.5 орчим хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байгаа хэдий ч цар тахлын дараа ажиллах хүчнээс гадуурх эрэгтэйчүүдийн тоо өсөх хандлагатай болсон байна.

## Зураг 6. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам


1. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам, түүний өөрчлөлт (мянган хүн, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тэмдэглэл: Ажиллах хүчнээс гадуурх хүн ам (АХГХ) өөрчлөлтийг өмнөх оны мөн үеэс өөрчлөгдсөн хувиар тооцов.

2. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам, цар тахлын өмнөх болон дараах тренд (мянган хүн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тэмдэглэл: Ажиллах хүчнээс гадуурх хүн амын цар тахлын өмнөх (ЦТӨ) болон цар тахлын дараах (ЦТД) трендийг хүйсээр ялган харуулав.

Дундаж цалингийн хэмжээ 2023 оны 3 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 27.3 хувиар өсөж, 2,009 мянган төгрөгт хүрлээ. Салбараар авч үзвэл, уул уурхайн салбарын дундаж цалин бусад салбараа тэргүүлж, улсын дунджаас 2.4 дахин өндөр байна.

## Зураг 7. Дундаж цалин

1. Дундаж цалин, түүний өөрчлөлт (мянган төгрөг, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тэмдэглэл: Дундаж цалингийн өөрчлөлтийг өмнөх оны мөн үеэс өөрчлөгдсөн хувиар тооцов.

2. Дундаж цалингийн өөрчлөлт (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тэмдэглэл: Бусад салбарт хөдөө аж ахуй, боловсруулах, цахилгаан, барилга, худалдааны салбарыг багтаав.

## 2. Төсвийн сектор


### Товч дүгнэлт

Уул уурхайн экспорт, түүний бүртгэл сайжирсан, дотоодын эдийн засаг идэвхэжсэнээр төсвийн орлого 2023 оны эхний 10 сард төлөвлөгөөнөөс 4.5 хувиар давж төвлөрч, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2.0 их наяд төгрөгийн ашигтай гарлаа.


**Төсвийн тэнцэл ашигтай гарлаа.** Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2023 оны эхний 10 сарын байдлаар 19.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 40.2 хувиар өссөн бол нэгдсэн төсвийн нийт зарлага 16.9 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 20.8 хувиар өссөн байна. Улмаар нэгдсэн төсвийн нийт тэнцэл 2023 оны эхний 10 сарын байдлаар 2.9 их наяд төгрөгийн ашигтай, тэнцвэржүүлсэн тэнцэл 2.1 их наяд төгрөгийн ашигтай гарлаа. Төсвийн бодлогын төлөвөөс үл хамааран төлөх үүрэг бүхий хүүгийн төлбөрт 2023 оны эхний 10 сарын байдлаар 1.0 их наяд төгрөгийг зарцуулсан бөгөөд нийт зарлагаас хүүгийн төлбөрийг хасаж тооцсон нэгдсэн төсвийн үндсэн тэнцэл тайлант хугацаанд 3.9 их наяд төгрөгийн ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 3.1 их наяд төгрөгөөр нэмэгдсэн нь төсөв хумьж байгааг харуулж байна.

### Зураг 8. Төсвийн орлого, зарлагын өөрчлөлт

1.Төсвийн орлогын голлох өөрчлөлтүүд (өмнөх онтой харьцуулснаар, их наяд төгрөг)



2.Төсвийн зарлагын голлох өөрчлөлтүүд (өмнөх онтой харьцуулснаар, тэрбум төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

Тэмдэглэл: Төсвийн зарлагын өөрчлөлтийн зурагт нийгмийн суурь үйлчилгээний байгууллагуудыг төсвийн хагас бие даасан тогтолцоонд шилжүүлэх зэрэгтэй холбоотойгоор Засгийн газрын дотоод шилжүүлэг эдийн засгийн ангилал хооронд шилжсэн томоохон зардлыг оруулаагүй болно.

**Уул уурхайн салбар төсвийн орлогын өсөлтийг дэмжлээ.** Төсвийн орлогын өсөлтөд нүүрсний экспорт төлөвлөснөөс өндөр гарсан болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг оновчтой бүрдүүлэх, олборлолтоос экспорт хүртэлх бүх үе шатанд цахим бүртгэл хийж, татварын тооцоолол, тайлагналыг хялбаршуулж автоматжуулсан нь голлон нөлөөлөв.

ДНБ-ий бүрэлдэхүүнд бүтээгдэхүүний цэвэр татвар хэлбэрээр бүртгэгддэг татварууд өмнөх оны мөн үеэс 1,435 тэрбум төгрөг буюу 34 хувиар өсжээ. Бүтцээр нь харвал экспортын голлох бүтээгдэхүүн болох нүүрсний олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа сайжирч, биржээр дамжуулан борлуулж байгаа нүүрсний экспортын өсөлтөөс голчлон шалтгаалж нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) болон гадаад үйл ажиллагааны орлого нэмэгдсэн байна. Харин импортын дизель түлшний онцгой албан татварыг 2023 оны 7 сарын 1-ний өдрийг хүртэл чөлөөлсөн шийдвэртэй холбоотойгоор онцгой албан татварын орлого буурсан байна.

Хүснэгт 1. Төсвийн үзүүлэлтүүд

Төсвийн үзүүлэлт (тэрбум төгрөг)	Гүйцэтгэл			Өөрчлөлт	
	2021.10	2022.10	2023.10	2023 vs 2022	
				₮	%
Бүтээгдэхүүний цэвэр татвар	3,764	4,210	5,645	1,435	34%
НӨАТ	2,285	3,137	3,778	640	20%
Гадаад үйл ажиллагааны орлого	772	1057	1189	133	13%
Онцгой албан татвар	696	734	660	-74	-10%
Тусгай зориулалтын орлого	12	16	18	2	13%
Тэтгэвэр, тэтгэмжийн зардал	5,524	6,914	8,327	1,413	20%
Нийгмийн даатгал	2,097	2,780	3,246	466	17%
Нийгмийн халамж	438	438	499	61	14%
Хүүхдийн мөнгө	1,210	1,237	1,265	28	2%
Хөрөнгийн зардал	1,779	2,459	3,317	858	35%

Өрхийн орлогыг дэмжихэд чиглэсэн төсвийн зардал нэмэгдлээ. Өрхийн орлогыг дэмжиж нийт эрэлтийг нэмэгдүүлдэг тэтгэвэр, тэтгэмжийн зардал энэ оны эхний 10 сард өмнөх оны мөн үеэс 1,413 тэрбум төгрөг буюу 20 хувиар нэмэгдсэн. Үүнд Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу өндөр насны болон нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлжээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд өмнөх онтой харьцуулахад 858 тэрбум төгрөгөөр илүү буюу 5.6 их наяд төгрөгийн төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 10 дугаар сарын байдлаар 59 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2023 оны 10 дугаар сарын байдлаар 2.1 их наяд төгрөгийн ашигтай гарахад уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт нэмэгдэж, тээвэрлэх, экспортлох үйл ажиллагаа сайжирч, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр өмнөх оны мөн үеэс 1.5 их наяд төгрөг буюу 68 хувиар, аж ахуй нэгжийн орлогын албан татвар 1.6 их наяд төгрөг буюу 78 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

### 3. Мөнгө ба санхүүгийн сектор

#### Инфляц ба мөнгөний бодлого

##### Товч дүгнэлт

Инфляц 2023 оны 11 дүгээр сарын гүйцэтгэлээр 8.6 хувьд хүрлээ. Инфляц буурахад гадаад валютын албан нөөц нэмэгдэж, валютын зах зээл тогтворжсоноор төгрөгийн ханш сулрах дарамт буурсан болон гадаад зах зээлд бараа, бүтээгдэхүүний үнэ буурсан нь нөлөөллөө.


Манай худалдааны гол түнш орнууд болох Орос, Турк, Солонгос, Япон зэрэг улсуудын жилийн инфляц өссөн бол Хятад, Америк, Их-Британи улсуудын инфляцын түвшин буурч байна. Сүүлийн сард дэлхийн хүнсний үнийн индекс өмнөх сараас 0.5 хувиар буурч, элсэн чихэр, үр тариа, ургамлын тос, махны үнэ буурсан ч сүүн бүтээгдэхүүний үнэ өссөн үзүүлэлттэй байна. Нөгөө талаас чингэлэг тээврийн үнэ цар тахлын өмнөх түвшинд хүрч өмнөх оны мөн үеэс 40 хувиар буурсан.

Инфляц буурч байгаа хэдий ч зарим улсуудын хөдөлмөрийн зах зээлийн идэвхжил өндөр, нийт эрэлт буурахгүй байгаа, ихэвчлэн өмнөх оны суурийн нөлөөгөөр буурч байгаатай холбоотойгоор улс орнууд мөнгөний бодлогын хүүг нэмэгдүүлсээр байна. 2023 он гарснаас хойш Евро бүс, Их Британи, Орос, Солонгос, Турк, АНУ бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн бол Киргизстан, Хятад, Шри-Ланк, Гүрж, Казакстан улсууд бодлогын хүүгээ бууруулсан.


Монгол Улсын жилийн инфляц 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 8.6 хувь болж өмнөх сараас 0.4 нэгжээр буурлаа. Инфляц өмнөх сараас буурахад хүнсний бүлэг 0.4 нэгж хувиар, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлэг 0.1 нэгж хувиар тус тус бууруулах нөлөө үзүүлсэн байна.

#### Зураг 9. Инфляцын бүтэц

1.Инфляцын жинлэсэн бүтэц (хувь)



2.Инфляцын бүрэлдэхүүн (хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, тооцоолол

Тэмдэглэл: Бараа, үйлчилгээний бүлгүүдийг нийт инфляцад эзлэх нэгж хувиар задлан харуулав.

Суурь инфляц өмнөх улирлаас 0.6 нэгжээр буурахад суурь үеийн нөлөө болон валютын ханш тогтворжсон зэрэг нь нөлөөлсөн байна. Суурь инфляц 2023 оны 11 дүгээр сард 4.8 хувь болж, өмнөх улирлаас буурсан хэдий ч цар тахлын өмнөх түвшнээс өндөр хэвээр байна.

Монгол улсын хэрэглээний сагсны нийт 410 барааны 220 буюу 46 хувийг импортын бараа, бүтээгдэхүүн, 190 буюу 54 хувийг дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээ бүрдүүлдэг. 2023 оны 11 дүгээр сард импортын барааны инфляц 3.1 нэгж хувийг бүрдүүлсэн нь нийт инфляцын 36.1 хувийг бүрдүүлж байна. Валютын зах зээл тогтворжиж, төгрөгийн ханш сулрах дарамт буурч, гадаад зах зээлд инфляц буурснаар импортын барааны инфляц тогтвортой буурах хандлагатай байгаа ч дотоодын бараа, үйлчилгээний инфляц нийт инфляцын 5.5 нэгж хувь буюу 63.9 хувийг эзэлж байгаа нь өндөр хэвээр байна.

Зураг 10. Жилийн инфляц ба суурь инфляц (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, ЭЗХЯ-ны тооцоолол

Тэмдэглэл: Суурь инфляцыг нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшийг хасаж тооцсон болно.

Бараа, үйлчилгээний үнийн өсөлтийг голлох бүлгээр нь задалбал хүнсний бүлгийн үнэ 2023 оны 11 дүгээр сард жилийн 13.3 хувийн (3.6 нэгж хувь) өсөлттэй гарахад мах, махан бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүний үнийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнийн жилийн 16.4 хувийн (0.5 нэгж хувь) өсөлтөд зоогийн газрын үнэ жилийн 25.2 хувиар өссөн нь голлон нөлөөлж байна. Дотоодын хүнсний бараа, бүтээгдэхүүний үнэ өндөр байгаа нь орцоор дамжин үнэд нөлөөлж байна. Тээврийн бүлгийн үнэ өнгөрсөн оны 11 дүгээр сард жилийн 7.7 хувийн (1.4 нэгж хувь) өсөлттэй байсан бол 2023 оны 11 дүгээр сард жилийн 0.9

хувийн (0.1 нэгж хувь) өсөлттэй гарлаа. Үнийн өсөлт буурахад АИ-92 автобензиний шатахууны үнэ сүүлийн нэг жилийн хугацаанд тогтвортой байгаа нь голлон нөлөөлсөн байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас Роснефть ХНХ-тэй хийсэн дараагийн хэлцлийн дагуу 2023 оны 3 дугаар сараас АИ-92 автобензинийг хямдралтай үнээр худалдаж авах нөхцөл бүрдээд байна. Мөн шатахууны гаалийн<sup>1</sup> болон онцгой албан татварыг 0 хувиар тогтоосноор АИ-92 автобензиний шатахууны үнэ тогтвортой байх нөхцөл бүрдсэн.

**Төсөв, мөнгөний бодлого инфляцыг хязгаарлах чиглэлд уялдаатай байна.** Монголбанк мөнгөний бодлогын хүүг 2022 онд 5 удаа нийт 7 нэгж хувиар нэмэгдүүлсэн ба 2023 оны 9 дүгээр сард бодлогын хүүг 13 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргасан. Мөн төсвийн үндсэн тэнцэл эерэг буюу ашигтай байгаа нь төсвийн бодлого нийт эрэлтийг бууруулах, инфляцыг хязгаарлахад чиглэж байгааг харуулж байна. Гэсэн хэдий ч эдийн засаг идэвхжиж, эрэлт нэмэгдэх, цалин өсөх, худалдааны түнш орнуудын инфляц эрчимжих, Украинд болж буй дайн зэрэг хүчин зүйлс инфляцын дарамтыг нэмэгдүүлж байна. Мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр зээлийн хүү өссөн хэдий ч сүүлийн саруудад шинээр олгосон зээл нэмэгдсэн байна.

<sup>1</sup> "Газрын тосны зарим бүтээгдэхүүний гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2023 оны 35 дугаар тогтоол (Импортоор оруулж байгаа 92 октантай автобензиний гаалийн албан татварын хувь, хэмжээг 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл 0 хувиар тогтоосугай)



## Санхүүгийн сектор

### Товч дүгнэлт

Мөнгөний нийлүүлэлт 2023 оны 10 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 23.6 хувиар буюу 6.4 их наяд төгрөгөөр нэмэгдэхэд төгрөгийн хадгаламж болон төгрөгийн харилцахын өсөлт голлон нөлөөлөв. Банкны салбарын шинээр олгосон зээлийн хэмжээ нэмэгдэж байна. Аж ахуй нэгжид шинээр олгосон зээл, иргэдэд шинээр олгосон зээлийн хэмжээнээс бага байна. Иргэдийн зээлийн дийлэнх хэсгийг хадгаламж барьцаалсан зээл болон цалингийн зээл бүрдүүлж байна.


**Мөнгөний нийлүүлэлт сүүлийн 2 улирал дараалан өслөө.** Мөнгөний нийлүүлэлт 2023 оны 10 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 23.6 хувиар өслөө. Мөнгөний нийлүүлэлт өсөхөд пассив талаас төгрөгийн хадгаламж болон төгрөгийн харилцахын өсөлт голлон нөлөөлсөн бол актив талаас гадаад цэвэр активын өсөлт, дотоод зээлийн өсөлт нөлөөллөө.

### Зураг 11. Мөнгөний үзүүлэлт

1. Мөнгөний нийлүүлэлт (пассив тал) (хувь)



2. Мөнгөний нийлүүлэлт (актив тал) (хувь)



Эх сурвалж: Монголбанкны статистик

Тэмдэглэл: Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг актив, пассив талын бүрэлдэхүүн доторх хувь нэмрээр харуулав.


Арилжааны банкнуудын актив, пассивын нэгдсэн тайлан тэнцэл өмнөх оны мөн үеэс 19.4 хувь буюу 8.0 их наяд төгрөгөөр нэмэгдлээ. Пассивын өөрчлөлтөд харилцах болон хадгаламж 4.2 их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн бол активын өөрчлөлтөд авлага 3.0 их наяд төгрөгөөр, төв банкны үнэт цаас 2.6 их наяд төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөөг үзүүллээ.

### Зураг 12. Арилжааны банкны хураангуй тайлан

1. Актив тал, жилийн өөрчлөлт (тэрбум төгрөг)



2. Пассив тал, жилийн өөрчлөлт (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк


Тэмдэглэл: Тайлант сарын эцсийн байдлаарх арилжааны банкуудын нэгдсэн тайлан тэнцэл

Арилжааны банкнуудын зээлийн үлдэгдэл 10 дугаар сарын байдлаар 26.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 3.5 их наяд төгрөгөөр буюу 15.7 хувиар өслөө. Арилжааны банкнуудын зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийг голлох салбаруудаар харвал, үл хөдлөх хөрөнгийн зээл 479 тэрбум төгрөг буюу 14.4 хувиар, худалдааны салбарын зээл 321 тэрбум төгрөг буюу 6.8 хувиар, барилгын салбарын зээлийн үлдэгдэл 160 тэрбум буюу 8.8 хувиар, боловсруулах салбарын зээл 154 тэрбум төгрөг буюу 8.9 хувиар, хөдөө аж ахуйн салбарын зээл 127 тэрбум төгрөг буюу 31.5 хувиар тус тус нэмэгдсэн байна. Харин уул уурхайн салбарын зээлийн үлдэгдэл 304 тэрбум төгрөгөөр буюу 19.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.


**Шинээр олгосон зээл оны эхнээс өссөн хэвээр байна.** Шинээр олгосон зээлийн хэмжээ 3.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 54.2 хувиар буюу 1.3 их наяд төгрөгөөр өссөн нь зээлийн эрэлт өндөр байгааг харуулж байна. Тус өсөлтийн 44.2 хувийг (578 тэрбум төгрөг) аж ахуй нэгжийн зээлийн өсөлт эзэлж байгаа бол 50.1 хувийг (655 тэрбум төгрөг) иргэдийн зээл, 5.7 хувийг (75 тэрбум төгрөг) улсын болон бусад байгууллагуудын зээл бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл, иргэдийн зээлийн эрэлт, аж ахуй нэгжийн эрэлтээс давсан үзүүлэлттэй байна. Цаашид аж ахуй нэгжийн зээл олголтыг түлхүү нэмэгдүүлснээр хувийн хэвшлийн үйл ажиллагаа идэвхжиж, эдийн засагт эергээр нөлөөлнө. Шинээр олгосон зээлийг иргэдэд болон аж ахуй нэгжид олгосон байдлаар нь авч үзвэл иргэдэд олгосон зээлийн хэмжээ 2.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 49.6 хувиар өсжээ. Үүний дийлэнх хэсгийг хадгаламж барьцаалсан зээл (529 тэрбум төгрөг буюу 26.7 хувь), цалингийн зээл (449 тэрбум төгрөг буюу 22.7 хувь), үл хөдлөх хөрөнгийн зээл (253 тэрбум төгрөг буюу 12.8 хувь) тус тус бүрдүүлсэн байна.

### Зураг 13. Зээл

1. Зээлийн үлдэгдэл, шинээр олгосон зээл (их наяд төгрөг)



2. Шинээр олгосон зээл салбараар (тэрбум, төгрөг)



Эх сурвалж: Монголбанкны статистик  
Тэмдэглэл: Цалин, тэтгэврийн зээлийн дүнг нэгтгэж тооцов.

Харин аж ахуй нэгжид шинээр олгосон зээлийн хэмжээ 1.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 57.1 хувиар өсжээ. Зээл олголтыг бүрэлдэхүүнээр нь харвал худалдааны салбарын зээл 51.0 хувийг (812 тэрбум төгрөг), барилгын салбарын зээл 14.8 хувийг (235 тэрбум төгрөг), боловсруулах салбарын зээл 11.0 хувийг (176 тэрбум төгрөг) тус тус бүрдүүлсэн байна.

**Чанаргүй зээлийн хэмжээ сүүлийн 3 улиралд тогтвортой байна.** Энэ оны 10 дугаар сарын байдлаар чанаргүй зээлийн хэмжээ 2.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.5 их наяд төгрөгөөр буурсан ба нийт зээлийн үлдэгдлийн 8.3 хувийг чанаргүй зээл, 5.3 хувийг хугацаа хэтэрсэн зээл эзэлж байна.

## 4. Гадаад сектор

### *Товч дүгнэлт*

Хилийн боомтуудын тээвэр зохион байгуулалт сайжирч, гадаад эрэлт тогтворжсоноор 2023 оны байдлаар чулуун нүүрсний экспорт түүхэн дээд түвшинд хүрлээ. Уул уурхай, тээврийн салбарын өсөлт өндөр байснаар дизель түлш, нүүрс тээврийн ачааны машины импорт нэмэгдлээ.

Нүүрсний экспортын биет хэмжээ нэмэгдсэнээр 2023 оны эхний 3 улирлын байдлаар төлбөрийн тэнцлийн ашиг улирлын давтамжтай статистикийн түүхэн дээд түвшинд хүрч, гадаад валютын албан нөөц 4 тэрбум ам.долларыг давлаа. Засгийн газар хугацаа нь тулаад байсан гадаад өр төлбөрийг дахин санхүүжүүлж, өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь төлбөрийн тэнцэл, гадаад валютын албан нөөцөд үзүүлэх дарамтыг буурууллаа.

### Гадаад худалдаа

Экспортын барааны урсгал нэмэгдэж, импортын барааны үнийн өсөлтийн дарамт бага байснаар гадаад худалдааны тэнцэл 4.9 тэрбум ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 23 хувиар өслөө. Гадаад худалдааны бараа эргэлт 2023 оны эхний 10 сарын байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 32.5 хувиар өсөж, 20.0 тэрбум ам.долларт хүрлээ. Экспорт өмнөх оны мөн үеэс 24.3 хувиар өсөж, 12.5 тэрбум ам.долларт, импорт өмнөх оны мөн үеэс 6.5 хувиар өсөж 7.6 тэрбум ам.долларт тус тус хүрснээр гадаад худалдааны тэнцэл 4.9 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.


**БНХАУ-ын хойд бүсийн мужуудын эдийн засгийн өсөлт 2023 оны эхний 3 улирлын байдлаар улсынхаа дундаж өсөлтөөс өндөр байгаа экспортын төлөвт эергээр нөлөөлж байна.** Гадаад эрэлт тогтвортой сайн байгаагаас шалтгаалан 2023 оны 11 дүгээр сарын эцсийн байдлаар чулуун нүүрсний экспорт 60 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 33 сая тонноор нэмэгдэж, нийт экспортын орлогын талаас илүү хувийг дангаараа бүрдүүлж байна.

Харин зэсийн баяжмал, алтны экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс буурлаа. Оюутолгойн зэсийн баяжмал дахь алтны агууламж багассанаас гадна цэвэр зэсийн үнэ өнгөрсөн оны эцсээс 4 хувиар буурсан нь зэсийн баяжмалын экспортын орлого буурахад нөлөөлөв. Алтны олборлолтын хэмжээ багассан нь алтны экспортын орлого буурахад нөлөөлөв.

**Худалдааны түнш орнуудын бараа, бүтээгдэхүүний үнэ өмнөх онтой харьцуулахад харьцангуй тогтворжиж, тээвэрлэлтийн саатал арилснаар импортын барааны үнийн дарамт бага түвшинд байна.** Өнгөрсөн оны эхний 10 сарын байдлаар импорт 1.5 тэрбум ам.доллараар өссөний 35 хувийг үнийн өсөлт бүрдүүлж байсан бол 2023 оны эхний 10 сарын байдлаар импорт 0.4 тэрбум ам.доллараар өссөний ердөө 4 орчим хувийг үнийн өсөлт бүрдүүлж байна.

**Тоног төхөөрөмжийн импорт нэмэгдэж, цаашид дотоодын боловсруулах үйлдвэрлэлийг дэмжихээр байна.** Тоног төхөөрөмжийн импорт 1.3 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 43.7 хувиар өслөө. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас чөлөөлснөөр тус барааны импорт 209 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 56.7 хувь өссөн. Мөн эрчим хүчний тасралтгүй байдлыг хангах үүднээс 80МВт суурилагдсан хүчин чадалтай хуримтлуурын байгууламжийг суурилуулж байгаа ба цахилгаан тоног төхөөрөмжийн импорт 296 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 52.8 хувиар өссөн.

## Зураг 14. Экспорт, импорт



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын статистик, ЭЗХЯ-ны тооцоолол  
Тэмдэглэл: Оны эхнээс өссөн дүнгээр харуулав.

**Уул уурхайн салбарыг дагасан бараа, бүтээгдэхүүний импортын өсөлт өндөр байна.** Шанагат ухагч, экскаваторын импорт өмнөх оны мөн үеэс 64.7 хувиар, нүүрс тээврийн хэрэгслийн импорт өмнөх оны мөн үеэс 72.5 хувиар өссөн. Оны сүүлийн саруудад нүүрсний экспорт саарах хандлагатай байдаг ч энэ онд гадаад эрэлт сайн байгаагаас шалтгаалж оны сүүлийн саруудад нүүрс тээвэрлэлт өндөр хэвээр байхаар байна. Дизель түлшний импорт 1,090 мянган тоннд хүрч 39.0 хувиар өссөн ч ОХУ-ын нефтийн бүтээгдэхүүний экспортын түр хориггоос шалтгаалан 9 болон 10 дугаар саруудын дизель түлшний импорт бага байснаар зах зээлд хомсдол үүсэж байна.

**Хүнсний бүтээгдэхүүний импорт буурлаа.** Хүнсний бүтээгдэхүүний импорт 773 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 137 сая ам.доллараар буурсны 71 хувь нь тоо хэмжээний бууралт байна. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж, согтууруулах ундааны онцгой албан татвар нэмэгдсэн ба согтууруулах ундааны импорт 45.4 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 34.5 хувиар буурсан байна.

### Төлбөрийн тэнцэл

**Экспортын орлого нэмэгдэж, төлбөрийн тэнцэл ашигтай гарлаа.** Засгийн газраас өнгөрсөн оны сүүлийн улирлаас эхлэн хэрэгжүүлж буй гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээнүүд болон БНХАУ-ын цар тахлын эсрэг хөл хорионы цуцлалттай холбоотойгоор экспорт сэргэж, 2023 оны эхний 3 улирлын байдлаар чулуун нүүрсний экспорт өмнөх оны мөн үеэс 28 сая тонноор буюу 146 хувиар нэмэгдлээ. Улмаар өнгөрсөн оны 3 дугаар улирлын эцэст 1.8 тэрбум ам.долларын алдагдалтай гарсан төлбөрийн тэнцэл 2023 оны 3 дугаар улирлын эцэст 0.8 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Экспортын өсөлтөөс шалтгаалан урсгал дансны ашиг өмнөх оноос 2.3 тэрбум ам.доллараар нэмэгдсэн бол худалдааны урьдчилгааны эргэн төлөлттэй холбоотойгоор санхүүгийн дансны ашиг өмнөх оноос 0.5 тэрбум ам.доллараар буурсан байна.

**Уул уурхайн экспортын өсөлт урсгал данс ашигтай гарахад нөлөөллөө.** Нүүрсний экспортыг өсөлтөөс шалтгаалан барааны экспорт өмнөх оноос 3.5 тэрбум ам.доллараар өссөн бол импортын өсөлт саарч, өмнөх оноос 0.6 тэрбум ам.доллараар нэмэгдсэн нь урсгал дансны тэнцлийг сайжрахад нөлөөллөө. Үйлчилгээний хувьд тээврийн салбарын идэвхжил нэмэгдсэнтэй холбоотойгоор тээврийн үйлчилгээний экспорт өмнөх оноос 0.2 тэрбум ам.доллараар өссөн, жуулчдын тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор<sup>2</sup> аялал жуулчлалын экспортын орлого өмнөх оноос 0.3 тэрбум ам.доллараар өссөн нь

<sup>2</sup> Улсын хилээр орсон жуулчдын тоо 2023 оны эхний 3 улиралд 486 мянга болж, өмнөх оноос 275 мянган жуулчнаар нэмэгдсэн.


нийт үйлчилгээний экспорт өмнөх оноос 0.5 тэрбум ам.доллаароор нэмэгдэхэд голлон нөлөөллөө. Нөгөө талаас тээврийн салбарын идэвхжилтэй холбоотойгоор тээврийн үйлчилгээний импорт өмнөх оноос 0.3 тэрбум ам.доллаароор, гадаадад аялагчдын тоо нэмэгдсэнээр<sup>3</sup> аяллын үйлчилгээний зардал өмнөх оноос 0.2 тэрбум ам.доллаароор тус тус нэмэгдсэн байна. Мөн техникийн, худалдааны болон бизнесийн бусад үйлчилгээний импорт өмнөх оноос 0.2 тэрбум ам.доллаароор нэмэгдсэн нь үйлчилгээний дансны алдагдлыг нэмэгдүүлээ.

**Санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс буурлаа.** Хөрөнгө оруулалтын буцаалтыг оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал 2023 оны эхний 3 улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 7 хувиар буюу 78 сая ам.доллаароор буурч 1,006 сая ам.долларт хүрсэн байна. Эргэн төлөлт нэмэгдсэнтэй холбоотойгоор худалдааны зээл, урьдчилгааны дансны тэнцэл өмнөх оноос 556 сая ам.доллаароор муудаж, 434 сая ам.долларын алдагдалтай гарсан нь санхүүгийн дансны ашиг буурахад нөлөөллөө. Засгийн газар болон хувийн хэвшлийн зээлийн ашиглалт төлөлтөөсөө давсан нь санхүүгийн дансны орох урсгалыг дэмжлээ.


**Урсгал дансны тэнцэл сайжирлаа.** Хадгаламж, хөрөнгө оруулалтын талаас нь тайлбарлавал урсгал дансны алдагдал нь тухайн эдийн засаг нийт хадгаламжаасаа давсан хөрөнгө оруулалт хийж байгааг харуулдаг. Сүүлийн 4 улирлын дунджаар тооцсон ДНБ-д харьцуулсан урсгал дансны алдагдал 2023 оны 3 дугаар улирлын эцэст -0.2 хувьд хүрч, алдагдал түүхэн доод түвшинд хүрлээ. Үүнд төсвийн орлогын өсөлтөөс шалтгаалан ДНБ-д харьцуулсан Засгийн газрын хадгаламж өмнөх оны мөн үеэс 7.8 нэгж хувиар нэмэгдсэний зэрэгцээ Засгийн газрын хөрөнгө оруулалт 0.1 нэгж хувиар, хувийн хөрөнгө оруулалт 6.2 нэгж хувиар тус тус буурсан нь нөлөөллөө.

Зураг 15. Төлбөрийн тэнцэл, урсгал дансны тэнцэл

1.Төлбөрийн тэнцэл, тухайн улирал (сая ам. доллар)



2.Хадгаламж, хөрөнгө оруулалтын зөрүү (ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: Монголбанкны статистик, ЭЗХЯ-ны тооцоолол  
Тэмдэглэл: ДНБ-д эзлэх хувийг 4 улирлын дунджаар тооцов.


**Гадаад валютын дуудлага худалдааны дүн буурлаа.** Экспортын орлого нэмэгдсэнээр Монголбанк 2023 оны эхний 3 улиралд нийт 3.0 тэрбум ам.долларыг дуудлага худалдаагаар зах зээлд нийлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 1.3 тэрбум ам.доллаароор буурсан үзүүлэлт боллоо. Гадаад валютын албан нөөц өмнөх оны 3 дугаар улирлын эцэст 2.8 тэрбум ам.долларт хүрч буураад байсан бол 2023 оны 3 дугаар улирлын эцэст 4.1 тэрбум ам.доллар буюу бараа, үйлчилгээний импортын 3.6 сарын хэрэгцээг<sup>4</sup> хангах түвшинд хүрч нэмэгдлээ.

<sup>3</sup> Улсын хилээр гарсан дотоодын жуулчдын тоо 2023 оны эхний 3 улиралд 1 сая 438 мянга болж, өмнөх оноос 1 сая зорчигчоор нэмэгдсэн.


<sup>4</sup> Сүүлийн 1 жилийн бараа, үйлчилгээний импортын дунджаар тооцсон сарын хүрэлцээт түвшин

## Зураг 16. Гадаад валютын албан нөөц


1.ГВАН (сая ам.доллар)



2.ГВАН хүрэлцээт түвшин (ARA хэмжүүрт эзлэх хувь)



3.Гадаад валютын дуудлага худалдаа (сая ам.доллар)




Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанкны статистик

Тэмдэглэл: ОУВС-гийн гадаад валютын нөөцийн хүрэлцээт түвшингийн ARA (Assessing Reserve Adequacy) хэмжүүрт хүрэлцээт нөөцийн түвшинг (i) экспортын орлого (ii) мөнгөний нийлүүлэлт (iii) богино хугацаат гадаад өр (iv) бусад гадаад өр төлбөрийг тус тус 5 хувь, 5 хувь, 30 хувь, болон 15 хувиар жигнэн тооцдог. Гадаад валютын нөөцийн хэмжээг ARA хэмжүүрийн 100-150 хувьтай тэнцэхүйц байхыг зөвлөдөг.


**Гадаад өр төлбөрийн дүн өндөр хэвээр байна.** Манай улсын гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц 2023 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс 102 сая ам.доллараар бага буюу - 41.8 тэрбум ам.долларт хүрсэн нь сүүлийн 4 улирлын дунджаар ДНБ-ий -224 хувьтай тэнцэж байна. Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц нь гадаад улсад байршиж буй Монгол улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгө болон Монгол улс бусад улсад төлөх үүрэг бүхий өр төлбөрийн зөрүүг харуулдаг. Гадаад актив буюу манай эдийн засгийн харьяатын эзэмшиж буй хөрөнгийн хамгийн өндөр буюу 51 хувийг (4,124 сая ам.доллар) нөөц хөрөнгө, харин 25 хувийг (2,003 сая ам.доллар) бэлэн мөнгө ба харилцах эзэлж байна.

## Зураг 17. Гадаад хөрөнгө оруулалтын позиц


1.Гадаад хөрөнгө оруулалтын позиц (ДНБ-д эзлэх хувь)



2.Гадаад активын задаргаа (ДНБ-д эзлэх хувь)



3.Гадаад пассивын задаргаа (ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: Монголбанкны статистик, ЭЗХЯ-ны тооцоолол

Тэмдэглэл: ДНБ-д эзлэх хувийг сүүлийн 4 улирлын дунджаар тооцов.


Гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх чиглэлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2023 оны эхний 3 улирлын байдлаар нөөц хөрөнгө 1.3 тэрбум ам.доллараар нэмэгдсэн байна. Харин нийт өр төлбөр буюу гадаад пассивын 60 хувийг (29.7 тэрбум ам.доллар) шууд хөрөнгө оруулалт, 27 хувийг (13.7 тэрбум ам.доллар) зээл, 7 хувийг (3.4 тэрбум ам.доллар) багцын хөрөнгө оруулалт эзэлж байна. Монгол улсад байршиж буй, гадаад улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгийн дүн гадаад улсад байршиж буй Монгол улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгөөс хэт өндөр байгаа нь манай улсын эдийн засаг гадаад шокоос үүдэлтэй хямралд

өртөх эрсдэл өндөр байгааг харуулж байна. Иймд экспортын орлогыг дэмжих, эдийн засгийг төрөлжүүлэх, гадаад өрийг бууруулах замаар болзошгүй гадаад шокуудыг давж гарах чадамжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.


**Хувийн хэвшлийн өр нийт гадаад өрийн дийлэнх хувийг бүрдүүлж байна.** Монгол Улсын нийт гадаад өр 2023 оны эхний 3 улирлын байдлаар 34.0 тэрбум ам.долларт хүрч, ДНБ-ий 182 хувьтай тэнцэж байна. Өнгөрсөн улиралтай харьцуулахад Засгийн газар, төв банк, банкнуудын гадаад өрийн үлдэгдэл 202 сая ам.доллороор буурсан ч бусад хувийн хэвшлийн гадаад өрийн үлдэгдэл 403 сая ам.доллороор нэмэгдсэн нь Монгол Улсын нийт гадаад өр өмнөх улирлаас 200 сая ам.доллороор нэмэгдэхэд нөлөөллөө. Гадаад өрийн бүтцийг харвал нийт өрийн 23 хувь буюу 7.9 тэрбум ам.доллар нь Засгийн газрын өр, 6 хувь буюу 2.0 тэрбум ам.доллар нь төв банкны өр, үлдсэн 71 хувь нь хувийн хэвшлийн өр байна. Хувийн хэвшлийн нийт гадаад өрийн дийлэнх буюу 75 хувийг уул уурхайн салбар, 11 хувийн санхүүгийн салбар, 4 хувийг худалдааны салбар, 3 хувийг үл хөдлөх салбар, 2 хувийг боловсруулах салбар, үлдсэн 6 хувийг бусад 16 салбарын өр бүрдүүлж байна. Нийт гадаад өрийг хугацаагаар нь харвал урт хугацаат өр 53 хувийг, шууд хөрөнгө оруулалтын компани хоорондын зээллэг 41 хувийг, богино хугацаат өр 5 хувийг бүрдүүлж байна.

### Зураг 18. Гадаад өр


1.Гадаад өр (ДНБ-д эзлэх хувь)



2.Гадаад өр (сая ам.доллар)



3.Хувийн хэвшлийн гадаад өр (сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанкны статистик, ЭЗХЯ-ны тооцоолол  
Тэмдэглэл: ДНБ-д эзлэх хувийг сүүлийн 4 улирлын дунджаар тооцов.



### Шигтгээ 1. Ноос, ноолуурын хялгас ялгах үйлдвэрүүдэд хийсэн хяналт шалгалт

Монгол Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2023 оны 05 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын 2022 оны 19 дүгээр тогтоолын хэрэгжилт болон ноос, ноолуурын боловсруулалтын талаар хяналт, шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж Улаанбаатар хотод байрлах хялгас ялгах үйлдвэр бүхий 45 ААН-ийн үйл ажиллагаатай танилцлаа.

#### Үйлдвэрүүдэд суурилагдсан хялгас ялгах үйлдвэрийн хүчин чадлын талаар

Улаанбаатар хотод байрлах нэр бүхий 45 хялгас ялгах үйлдвэрт 11,294 тонн самнасан ноолуур гаргах, Говьсүмбэр, Өвөрхангай, Баян-Өлгий, Орхон, Төв аймгуудад байрлах 5 хялгас ялгах үйлдвэрт 670 тонн самнасан ноолуур гаргах хүчин чадал суурилагдсан байна.

Дээрх үйлдвэрүүд нийтдээ 11,965 тонн самнасан ноолуур, ноос, хөөвөр гаргах хүчин чадал суурилагдсан байгаагийн 71.3 хувь буюу 8,530 тоннд нь ноолуур, 10 хувь буюу 1,130 тоннд нь хонь, тэмээ, сарлагийн хөөвөр тус тус боловсруулж, үлдсэн 17.9 хувьд засвар үйлчилгээ болон бусад шалтгааны улмаас сул зогсоно гэж тооцсон байна. Үүнээс, гаднын хөрөнгө оруулалттай 11 аж ахуйн нэгжид 3,700 тонн самнасан ноолуур гаргах хүчин чадал суурилагдсан байгаа нь улсын хэмжээнд байгаа нийт самнах хүчин чадлын 43.4 хувийг эзэлж байна.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 19 дүгээр тогтоол, Засгийн газрын 2022 оны 380 дугаар тогтоол батлагдсантай холбогдуулан 2022 болон 2023 онуудад нийт 15 үйлдвэрт 4,163 тонн хялгас ялгах хүчин чадал нэмж суурилагдсан байна. Үүнээс 2022 онд 3 үйлдвэрт 297 тонн, 2023 онд 12 үйлдвэрт 3,866 тонн хялгас ялгах хүчин чадал суурилагдсан байна.

#### Түүхий эдийн худалдан авалт, үйлдвэрлэлт, борлуулалтын талаар

Судалгаанд хамрагдсан үйлдвэр аж ахуйн нэгж (ААН)-үүд нь 2022 онд нийтдээ 4,901 тонн түүхий ноолуур худалдан авсан бол 2023 онд 6,314 тонныг худалдан авч 28.8 хувийн өссөн байна.

Ноолуурын салбарын экспортыг авч үзвэл 2021 онд 6,027 тонн угаасан ноолуур, 374.3 тонн самнасан ноолуур экспортолж байсан бол 2022 онд 6,412 тонн угаасан ноолуур, 857 тонн самнасан ноолуур (2 дахин өссөн) экспортолсон байна. 2023 оны эхний 10 сарын байдлаар угаасан ноолуур 1,999 тонн болж өссөн бол самнасан ноолуурын экспорт 667 тоннд хүрээд байна. Харин судалгаанд аж ахуй нэгжийн хувьд статистикийг харвал 2021 онд 7 ААН 394 тонн, 2022 онд 9 ААН 825 тонн, 2023 оны эхний 10 сарын байдлаар 11 ААН 667 тонныг тус тус ноолуур самнасан байна.

### Хүснэгт 2. Угаасан болон самнасан ноолуурын экспорт

(Судалгаанд хамрагдсан нэр бүхий 50 үйлдвэрээс угаасан болон самнасан ноолуур экспортолсон ААН)

Нэр төрөл	2021 он		2022 он		2023 оны эхний 10 сар	
	ААН	Экспорт, тонн	ААН	Экспорт, тонн	ААН	Экспорт, тонн
Угаасан ноолуур	8	1,950	9	1,530	10	1,999
Самнасан ноолуур	7	394	9	825	11	667

#### Хүний нөөцийн талаар

Судалгаанд хамрагдсан үйлдвэрүүдэд 4,220 хүн ажиллаж байгаагийн 3,873 нь үндсэн, 347 нь гэрээт ажилтан байна. Тус үйлдвэрүүдэд өнөөгийн байдлаар 1,584 хүн дутагдалтай байгаа ба 380 инженер техникийн ажилтан, 1,204 мэргэжилтэй ажилтан хэрэгцээтэй байна. Цаашид хялгас ялгах үйлдвэрлэлийн хүчин чадлаа бүрэн ашиглавал 4,000 гаруй хүний нөөцийн эрэлт үүсэхээр байна.

Үйлдвэрүүдэд нарийн мэргэжлийн ажилтан, инженер, техникийн ажилтны хангамж дутмаг, тогтвор суурьшил сул байна. Ноос, ноолуурын салбарт мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байгаа учраас ажил олгогч нар мэргэжилгүй, ажилгүй залуучуудыг авч ажиллуулж, ажлын байран дээр нь сургаж

дадлагажуулах арга хэмжээнүүдийг авч эхэлсэн нь энэ салбарт ажиллах боловсон хүчнээ бэлтгэхэд төрийн бодлого хэрэгтэй болсныг харуулж байна. Шалгалтад хамрагдсан нийт 15 үйлдвэрийн ажиллагчдын 60 орчим хувь нь бүрэн дундаас доош боловсролтой, ажлын байрны мэдээллийн эх сурвалжаас харахад ихэнх хувийг буюу 50 гаруй хувийг танилын хүрээнээс авч ажиллуулж байна.

Өнгөрсөн хугацаанд ноос, ноолуурын салбарт тоног төхөөрөмж, эргэлтийн хөрөнгө оруулалт сайжирсан хэдий ч мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх ажил хоцорч, мэргэжлийн хүний нөөцөөр хангаж чадахгүй, хүн хүч дутагдалтай байна. Үйлдвэрүүд хүний нөөцийг сургах, тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч байгаа хэдий ч цөөн хэдэн үйлдвэрээс бусад нь хүний нөөцийн дутагдалтай байна. Улмаар сүлжих, холбож оёх зэрэг тоног төхөөрөмжийн 30 хувийн сул зогсолтыг үүсгэсэн бөгөөд үйлдвэрлэлийн эцсийн бүтээгдэхүүний бүтээмжид нөлөөлөхүйц хэмжээнд хүрээд байна. Салбарын хүний нөөцийг эрэлт, шаардлагад тулгуурлан сургаж, мэргэшүүлэх замаар үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд салбарын мэргэжилтэй ажиллагчдыг төлөвлөж, эрэлтэд нийцсэн богино, урт хугацааны сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Нөгөө талаас зарим үйлдвэрүүдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаа хангалтгүй байна. Жижиг, дунд үйлдвэрийн ажиллагчдын тоо цөөн, аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулалт муу, үйл ажиллагааны дэмжлэг, санаачилга бага гэсэн дүр зураг харагдсан. Цаашид салбарын хүрээнд хүний нөөцийн тусгайлсан бодлого хэрэгжүүлэх нь нэн тэргүүнд хэрэгжүүлэх чухал алхам юм.

## Шигтгээ 2. Арьс шир, ноолуурын гадаад худалдаа


### Ноолуур

Угаасан ноолуур экспортод гаргахыг хориглох тухай техникийн зохицуулалтыг 2022 оны 10 дугаар сард баталсан. Улмаар, ноолуурын экспорт 2023 оны эхний 11 сарын байдлаар 280.1 сая ам долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 13 хувиар буурлаа. Түүнчлэн, дотоодын зах зээл дэх үнэ 114 мянган төгрөгөөс 88 мянган төгрөг болтлоо буурав. Уг техникийн зохицуулалтыг 2023 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн Засгийн газрын 66 дугаар тогтоолоор хойшлуулснаар малчин өрхийн жилийн орлогын 50 орчим хувийг бүрдүүлдэг ноолуурын үнэ унах эрсдэл саарч, дотоодын зах зээл дэх үнэ хэсэгчлэн өслөө.

Зураг 19. Дотоодын зах зээл дэх ноолуурын үнэ (мянган төгрөг)



Зураг 20. Арьс ширний экспорт (сая ам.доллар)



### Арьс шир

Боловсруулаагүй арьс ширийг экспортод гаргахыг хориглох тухай техникийн зохицуулалтыг 2013 оны 8 дугаар сард баталсан. Улмаар, арьс ширний экспорт 10 жилийн хугацаанд 10 дахин буурч, 2023 оны эхний 11 сарын байдлаар 3.5 сая ам долларт хүрлээ. Уг техникийн зохицуулалтыг 2023 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн Засгийн газрын 65 дугаар тогтоолоор хойшлуулснаар үхэр, адууны ширний экспорт 2022 оны эхний 10 сард 594 мянган ам.доллар байсан бол 2023 оны эхний 10 сард 648 мянган ам.доллар болж 9 хувиар өссөн

байна. 2014 оноос хойш 10 дахин буураад байсан экспортыг сэргээх боломжтой болж ОХУ, Турк, Итали, Узбекистан руу түүхий арьс шир экспортолж эхэллээ.


### Мах

2023 оны 10 дугаар сарын байдлаар 61 сая тонн буюу 241 сая ам.долларын мах, дайвар бүтээгдэхүүн экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс тоо хэмжээний хувьд 10 дахин, үнийн дүнгийн хувьд 13 дахин өссөн үзүүлэлт байна. 2023 оны 2 дугаар сард салбарын сайдын тушаалаар экспортлох махан бүтээгдэхүүн, хонь, ямааны түүхий болон дулааны аргаар боловсруулсан мах, адууны түүхий маханд 2024 оны 8 дугаар сар хүртэлх хугацаанд тоо хэмжээний хязгаарлалт тогтоохгүй байхаар шийдвэрлэснээр мах, махан бүтээгдэхүүний экспорт нэмэгдлээ.

### Шигтгээ 3. Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс


Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексээр Монгол Улс 2023 онд дэлхийн 176 орноос 73 дугаарт жагсжээ. Дэлхийн өв уламжлалын сангаас тооцоолон гаргадаг тус индекс нь Хуулийн засаглал, Засгийн газрын хэмжээ, Зохицуулалтын үр ашиг, Нээлттэй зах зээл гэсэн 4 бүлэг бүхий 12 шалгуур үзүүлэлтээр улс орнуудын эдийн засгийн нөхцөл байдлыг олон талаас харуулахын зэрэгцээ, иргэдийн хөгжих, хөдөлмөрийн үр ашгаа хүртэх эрх чөлөөг хэмждэг. Тус индексийг 0-100 онооны хооронд үнэлж гаргадаг бөгөөд индекс 100-д ойртох тусам эдийн засгийн эрх чөлөө өндөр байна гэж үздэг.

Зураг 21. Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс



Монгол Улс 2023 онд эдийн засгийн эрх чөлөөгөөр 61.7 оноо авсан нь дэлхийн дунджаас 2 оноогоор, Ази номхон далайн бүсийн орнуудын дунджаас 3 оноогоор илүү байна. Индексийн 4 бүлгээс Засгийн газрын хэмжээ (72 оноо) болон Зохицуулалтын үр ашиг (69 оноо) гэсэн бүлгүүдээр сайн үнэлэгдсэн бол Зах зээлийн нээлттэй байдал (58 оноо) болон Хуулийн засаглал (47 оноо) бүлгүүдээр сул үнэлгээ авчээ.

Зураг 22. Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ



Сүүлийн 5 жилийн хугацаанд манай улсын Төсвийн сахилга бат, Шүүхийн үр ашгийн үнэлгээ эрс сайжирсан байна. Тухайлбал 2019 онд Монгол Улсын Төсвийн сахилга бат 6.2 оноо байснаас 2023 онд оноо 64.3 оноо, Шүүхийн үр ашиггүй байдал 2019 онд 23.8 оноо байснаас 2023 онд 55.8 оноо болж тус өссөн байна.

#### Шигтгээ 4. Нефтийн бүтээгдэхүүний импорт

Монгол улс 2023 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 1.7 тэрбум төгрөгөөр 2,155 мянган тонн нефтийн бүтээгдэхүүнийг импортолж хэрэглэсэн байна. Нефтийн бүтээгдэхүүний импортын 57 хувийг дизелийн түлш, 28 хувийг бензин, 15 хувийг бусад нефтийн бүтээгдэхүүн бүрдүүлж байна.


#### Дизелийн түлш

2023 оны эхний 11 сарын байдлаар 1,195 мянган тонн дизелийн түлш импортолсон нь өмнөх оны мөн үеэс 37.9 хувиар өссөн дүн байв.


ОХУ-Украины нөхцөл байдлаас шалтгаалан нефтийн бүтээгдэхүүний үнэ өссөн ба 2022 онд дизелийн түлшний импорт 315 сая ам.доллаароор өссөний 100 хувь үнийн өсөлт байсан. Харин 2023 оны эхний 11 сарын байдлаар дизель түлшний импорт 107 сая ам.доллаароор өссөний 87 хувийг тоо хэмжээний өсөлт бүрдүүлж байна.

Энэ оны эхний 3 улирлын байдлаар уул уурхайн салбар 33 хувиар, тээврийн салбар 58 хувиар өсөж, 2023 оны 11 сарын байдлаар нүүрсний экспорт 60 сая тоннд хүрсэн зэрэг нь дизелийн түлшний импорт өсөхөд голлох нөлөө үзүүлсэн байна.

Зураг 23. Дизелийн түлшний импорт (сарын гүйцэтгэл, мянган тонн)



Зураг 24. Бензиний импорт (сарын гүйцэтгэл, мянган тонн)



#### Бензин

2023 оны эхний 11 сарын байдлаар 659.1 мянган тонн бензин импортолж, өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар өссөн. Бензиний төрлөөр авч үзвэл 94.1 хувийг АИ-92, 2.8 хувийг АИ-95, 3.1 хувийг А-80 бүрдүүлж байна.

2023 оны эхний гурван улирлын байдлаар өрхийн хүнсний хэрэглээ буурч, хүнсний бус хэрэглээ өссөн ба автомашины импорт нэмэгдэж байгаа нь бензиний импорт өсөхөд нөлөөлөө.

#### ОХУ-ын түлш, шатахууны хориг

ОХУ дайны нөхцөл байдлаас шалтгаалан дотоод дахь түлш, шатахууны хэрэгцээ өссөн тул 2023 оны 9 дүгээр сарын 21-ний өдрөөс түлш, шатахууны экспортыг түр хугацаанд хориглосон. Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын бензин, дизелийн түлшний импорт 15 хоног саатаж, 9 болон 10 дугаар сарын импорт өмнөх саруудаас буурсан. ОХУ-аас нефтийн бүтээгдэхүүнд тавьсан хориг манай улсад хамаарахгүйг мэдэгдэж, импорт хийгдэж эхэлсэн ба 11 дүгээр сард 110 мянган тонн дизелийн түлш, 67 мянган тонн бензин импортолсон.